



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 4/310

Улаанбаатар хот


Г Зоонозын өвчин судлалын үндэсний
төвийн бүтэц, дүрэм шинэчлэн
батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн бүтцийг нэгдүгээр, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан бүтэц, дүрмийг одоо байгаа орон тоо, төсөвт багтаан мөрдөн ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2016 оны “Бүтцэд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 17 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын (хуучин нэрээр) 2015 оны “Дүрэм, бүтэц батлах тухай” 58 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД


Д.САРАНГЭРЭЛ



081150

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 06.сарын 27.-ны өдрийн
A/310 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ



Эрүүл мэндийн сайдын
2019 оны 06. сарын 22-ны өдрийн
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эрүүл мэндийн яамны харьяа Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төв (цаашид ЗӨСҮТ гэх) нь зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварын эрсдэлийг бууруулж, хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүрэг бүхий тусгай мэргэжлийн үндэсний төв мөн.
- 1.2. Төв нь улсын хэмжээнд зоонозын халдварт өвчний хяналт сэргийлэлт, тандалт, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, аргачлал боловсруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, байгалийн голомт, хүн амын өвчлөлийн тархалт, нас баралтыг тандан судлах, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллага болно.
- 1.3. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 281 дугаар тогтооолоор цагдаа, дотоодын цэргийн хамгаалалт бүхий улсын онц чухал объект болно.
- 1.4. Төв нь зоонозын халдварт өвчний чиглэлээр улсын хэмжээнд мэргэжлийн дүгнэлт гаргаж, зөвлөгөө өгөх дээд байгууллага бөгөөд холбогдох хууль, тогтоомжийн дагуу тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, бэлгэдэл, санхүүгийн харилцах данстай байна.
- 1.5. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүй, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журам болон Эрүүл мэндийн сайдаар батлуулсан энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулна.
- 1.6. Төв нь байгууллагын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй байна.
- 1.7. Төв нь “Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Монгол улс, Улаанбаатар хот 18131, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо” гэсэн хаягтай байна.
- 1.8. Төвийн нэрийг англиар “National Center for Zoonotic Diseases” гэж нэрлэнэ.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

- 2.1. Төв нь үйл ажиллагаанд даацах зарчмыг баримтална. Үүнд:
 - Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
 - Үйлчлүүлэгчийг дээдлэн тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
 - Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
 - Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих;
 - Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан

гаргах;

- Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх;

2.2. Төвийн эрхэм зорилго

Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварын эрсдэлийг багасгах замаар хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулахад төвийн эрхэм зорилго оршино.

2.3. Төвийн үнэт зүйлс:

- 2.3.1. Байгууллагын түүхэн замнал, соёл, уламжлал, бахархал
- 2.3.2. Мэргэшсэн, ёс зүйтэй, ур чадвартай хүний нөөц
- 2.3.3. Удирдлагын манлайлал, хариуцлага, ил тод байдал, эрхэм зорилго, зорилт
- 2.3.4. Эвсэг, хамтаж байдал

Гурав. Төвийн үндсэн чиг үүрэг

- 3.1. Улсын хэмжээнд зоонозын халдварт өвчинүүдийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,
- 3.2. Чиг үүргийн хүрээнд хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах, зоонозын өвчний тархалтын тандалт судалгааг хийх, хүн амыг уг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх,
- 3.3. Зоонозын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал боловсруулж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,
- 3.4. Монгол улсын хэмжээнд зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжлийг тогтоож, эрсдэлийн дагуу бүсчлэх,
- 3.5. Зоонозын өвчний дэгдэлтийн үед голомтод эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах,
- 3.6. Чиг үүргийн хүрээнд орон нутгийн харьяа байгууллагууд болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх,
- 3.7. Чиг үүргийн хүрээнд лабораторийн лавлагаа тусlamж, үйлчилгээ үзүүлэх, улсын хэмжээнд зоонозын халдварт өвчний мэдээллийн сан бүрдүүлэх

Дөрөв. Төвийн эрх, үүрэг

4.1. Төв нь дараах эрхтэй:

- 4.1.1. Зоонозын халдварт өвчний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм стандарт, эмнэлзүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 4.1.2. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл, эрдмийн болон мэргэжлийн зэрэг, ур чадварын ба бусад нэмэгдлийг зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу олгож, захиран зарцуулах;

- 4.1.3. Ижил чиг үүрэг бүхий гадаадын лавлагаа төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн тусlamж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох;
- 4.1.4. Судалгаа шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах;
- 4.1.5. Гадаад, дотоодын ижил төсөөтэй төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээ байгуулах;
- 4.1.6. Харилцан ойлголцлын санамж бичиг, гэрээ хэлэлцээрийн хүрээнд мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, гадаадын мэргэжилтнээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх, олон улсын байгууллагаас мэргэжилтэн, зочид, төлөөлөгч урих;
- 4.1.7. Төв нь тусlamж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх;
- 4.1.8. Төв нь хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусlamж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;
- 4.1.9. Аж ахуйн бие даасан, эдийн засгийн үр ашигтай үйл ажиллагаа явуулах, эд хөрөнгө захиран зарцуулах, био бэлдмэл үйлдвэрлэх, экспортлох, импортлох, машин, тоног төхөөрөмж, оношлуур, урвалж бодисыг ханганд нийлүүлэх;
- 4.1.10. Гамшгаас хамгаалах болон гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, холбогдох хариу арга хэмжээг хэрэгжүүлэх,
- 4.1.11. Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүсгэж болзошгүй үед шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хувь хүнээс гаргуулах;
- 4.1.12. Зоонозын халдварт өвчний асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран шинжээчийн хэсгийг томилж, магадлагаа, дүгнэлт гаргуулах;
- 4.1.13. Зоонозын халдварт өвчний чиглэлээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх, давтан сургалтыг зохион байгуулах, шавилан сургалт явуулах, сургалтын хөтөлбөр, стандартыг боловсронгуй болгох, сургалт эрхлэх байгууллага болох/байх;
- 4.1.14. Судалгаа шинжилгээний болон эрдмийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлд экспертиз хийх, санал, дүгнэлт, шүүмж бичих, магистр, докторын зэрэг горилогчийн талаар санал дүгнэлт гаргах, үндэсний төвийн судалгаа шинжилгээний бүтээл, тайлан, эрдэм шинжилгээний хурлын материалыг хэвлэн нийтлэх;
- 4.1.15. Судалгаа шинжилгээ, практикийн ажилд үр бүтээл гаргаж, залуу үеийг сургаж дадлагажуулах, гадаад харилцааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаад, дотоодын эмч, мэргэжилтнүүдэд Үндэсний төвийн “Хүндэт тэмдэг” олгох, “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулах, “Хүндэт профессор” цолоор өргөмжлөх;

4.1.16. Аймаг, нийслэл дэх Зоонозын өвчин судлалын төвийн даргыг томилох, чөлөөлөх асуудлыг орон нутгийн Эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөх, үйл ажиллагааны турвалсан гэрээ байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг тооцох.

4.1.17. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх;

4.2. Төв нь дараах үүрэгтэй:

- 4.2.1. Зоонозын халдварт өвчний тохиолдол, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг эрүүл мэндийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах;
- 4.2.2. Аймаг, дүүргийн ЗӨСТ-өөс үзүүлж буй тусlamж, үйлчилгээ, оношилгоо, лабораторийн шинжилгээнд чанарын хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
- 4.2.3. Төв нь зоонозын халдварт өвчний үйл ажиллагааны чиглэлээр оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, аргачлал, бодлогын баримт бичгүүдийг улсын хэмжээнд боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тусlamж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх;
- 4.2.4. “Олон улсын эрүүл мэндийн дүрэм”, зоонозын халдварт өвчний талаарх Олон улсын болон Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөх, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан халдварт хамгааллын дэглэм болон биоаюулгүй ажиллагааны заавар, журмыг баримтлах;
- 4.2.5. “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын хүрээнд зоонозын өвчлөлийн чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох
- 4.2.6. Төв нь төгсөлтийн дараах албан ба албан бус сургалтыг зохион байгуулах, эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжлийн зэргийн шалгалт болон гадаад, дотоодын магистрантур, докторантурын сургалтад хамруулах, доод шатны эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулан ажлын байрны болон зайн сургалт явуулах, сургахад шаардлагатай материаллаг болон хүний нөөцийг бүрдүүлэх;
- 4.2.7. Тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;
- 4.2.8. Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, цахим бүртгэлийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;
- 4.2.9. Зоонозын халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах, хянах, сэргийлэх, эмнэлзүйн судалгаа шинжилгээг гүйцэтгэж оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох;

- 4.2.10. Төв нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэн ажиллах;
- 4.2.11. Зоонозын халдварт өвчний асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх, төсөл, суурь судалгааны сэдэвт ажил хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны хүрээнд хамтарсан судалгаа шинжилгээ хийх;
- 4.2.12. Үндэсний болон олон улсын хэмжээнд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, оролцох, бүтээл хэвлүүлэх;
- 4.2.13. Халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний улсын фондын хөрөнгийн хадгалалт, ашиглалтад хяналт тавих, захиран зарцуулах, нөхөн хангалтын арга хэмжээг зохион байгуулах;
- 4.2.14. Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт болон голомтын үеийн ариутгал, халдвартгүйтгэл, мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэх;
- 4.2.15. Зоонозын халдварт өвчний чиглэлээр лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх, мэргэжил, арга зүйгээр хангах;
- 4.2.16. Зоонозын халдварт өвчин үүсгэгчдийн өсгөвөр, омгийн, ийлдсийн, сорьцын санг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, баяжуулах, судлах;
- 4.2.17. Зоонозын халдварт өвчний вакцин, ийлдэс, оношлуур, биобэлдмэл, тэжээлт орчин, будаг урвалж үйлдвэрлэх, турших, нийлүүлэх.
- 4.2.18. Төв нь санхүү төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит болон нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж “Шилэн дансны тухай” хуулийг мөрдөн ажиллах
- 4.2.19. Ажилчдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцөлийг сайжруулах талаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн санаачилгатай ажиллах;
- 4.2.20. Төв нь ажилчдын мэдлэг ур чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга хариуцлагын хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;
- 4.2.21. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг

Тав. Үндэсний төвийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт

- 5.1. Төвийн удирдах дээд албан тушаалтан нь ерөнхий захирал байх бөгөөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.
- 5.2. Төвийн удирдлагын тогтолцоо нь ерөнхий захирал болон түүний дэргэдэх удирдлагын болон эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ.
- 5.3. Төвийн ерөнхий захирал нь алба, нэгжийн удирдлага, үйлдвэрчний эвлэл, ажилчдын төлөөллийг оролцуулсан удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.
- 5.4. Төв нь эрдэм шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх, зоонозын өвчин судлалын чиглэлээр эрдэм судлалын ажлыг үндэсний хэмжээнд

зохицуулах үүрэг бүхий эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг төвийн ерөнхий захирал батална.

- 5.5. Төвийн ерөнхий захирлын тушаал, удирдлагын болон эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл хөтөлнө.
- 5.6. Төвийн ерөнхий захирлын эрх, үүрэг
 - 5.6.1. Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;
 - 5.6.2. Төвийн дэд захирал, алба, тасаг нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн хөгжлийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
 - 5.6.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төвийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;
 - 5.6.4. Байгууллагын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа алба, нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулж томилох;
 - 5.6.5. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийн тайланг байгууллагын хурлаар хэлэлцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд мэдээлэх;
 - 5.6.6. Төвийн ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, гэрээг цуцлах;
 - 5.6.7. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр төвийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах;
 - 5.6.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах;
 - 5.6.9. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах,

Зургаа. Төвийн санхүүжилт

- 6.1. Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
 - 6.1.1. Улсын төсөв;
 - 6.1.2. Үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон ашиг, орлого гэх мэт);
 - 6.1.3. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүнээс авсан хандив, тусlamж;
 - 6.1.4. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт,
 - 6.1.5. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

Долоо. Хамтын ажиллагаа

- 7.1. Төвийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд төвийн ерөнхий захирал төлөөлнө.
- 7.2. Төвийн ерөнхий захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал семинарт оролцох албан томилолтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, төрийн нарийн бичгийн даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 7.3. Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг төвийн ерөнхий захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 7.4. Төв нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын

удирдлагууд, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

- 7.5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага болон төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Найм. Төвийн дэд захирал, алба, тасгийн ерөнхий чиг үүрэг

Төв нь тусламж, үйлчилгээ үзүүлэх алба, тасаг нэгжүүдийн чиг үүргийг тодорхойлж өөрийн онцлогт тохируулан бүтцийг зохион байгуулна.

8.1. Дэд захирал

- 8.1.1. Төвийн ерөнхий захирлын шууд удирдлагад ажиллаж үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар захирлыг өдөр тутмын мэдээллээр хангах;
- 8.1.2. Холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд төвийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах;
- 8.1.3. Байгууллагын болон салбарын хэмжээнд үндсэн мэргэжлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, чиглүүлэх;
- 8.1.4. Байгууллагын болон салбарын ойрын болон хэтийн төлөвлөлт, эрх зүйн баримтын хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 8.1.5. Төвийн алба, тасгуудын үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулж үйл ажиллагааны үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- 8.1.6. Халдварт хариуцсан мэргэжлийн баг, комисс, хороо зэрэг байнгын болон байнгын бус ажлын хэсгүүдийг ахалж ажиллах бөгөөд үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж, удирдан зохион байгуулах;
- 8.1.7. Төвийн ерөнхий захирлын эзгүйд тодорхой асуудлын хүрээнд орлон ажиллах;
- 8.1.8. Төвийн үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх, ажилчдыг удирдан чиглүүлэх манлайлах, хамт олныг зөв зохион байгуулах, удирдах албаны болон байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж хууль эрх зүйн хүрээнд ажиллуулах;
- 8.1.9. ЗӨСТ-үүд болон бусад эрүүл мэндийн байгууллагуудыг эрхлэх асуудлын хүрээнд мэргэжил аргазүй, хууль эрхзүй гэх мэт бүх талын мэдээ, мэдээллээр хангаж үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 8.1.10. Төвийн бүтэц, алба, тасаг, аймаг, нийслэлийн ЗӨСТ-ийн үйл ажиллагааны чиглэл, дотоод журам, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;
- 8.1.11. Гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх, туршлага солилоцох зэрэг асуудлаар санал боловсруулж танилцуулах, харилцан ойлголцлын санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээ боловсруулах;

8.2. Захиргааны алба

- 8.2.1. Захиргааны албаны дарга нь албаны өдөр тутмын үйл ажиллагааг ерөнхий захирал, дэд захирлын удирдлага дор зохион байгуулах;
- 8.2.2. Байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө, стратеги, маркетингийн зураглалыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих;
- 8.2.3. Байгууллагын алсын хараа, хэтийн зорилтыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого шийдвэртэй нийцүүлэн боловсруулах;
- 8.2.4. Байгууллагын дотоод журам, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах;
- 8.2.5. Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөр, хууль, журам, тушаал, бусад шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, төлөвлөх, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах,
- 8.2.6. Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, чадавхжуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ажилтнуудын хувийн хэрэг, мэдээний санг хөтлөх, тогтмол баяжилт хийх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, албан хаагчидтай холбоотой шийдвэр гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлж ажиллах;
- 8.2.7. Ажилчдын нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- 8.2.8. Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, бодлогын болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ хийх;

8.3. Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, технологийн алба

- 8.3.1. Зоонозын өвчний чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхлэх, зөвлөмж боловсруулах, судалгааны болон мэдээний сан үүсгэх;
- 8.3.2. Олон улсад нэвтэрч буй анагаах ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах, гадаад харилцааг өргөжүүлэн олон улсын байгууллагатай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан харилцан туршлага солилцох, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах;
- 8.3.3. Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн ажилтнуудын ажлын байран дахь зайн болон төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, эрүүл мэндийн чиглэлээр эмч мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах;
- 8.3.4. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах боломжит бүх арга хэмжээг авч мэдээлэл хамгаалалтын систем бий болгох, сүлжээний аюулгүй байдал, нууцлал хамгаалалтын чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

- 8.3.5 Интернет болон компьютерын сүлжээний үйлчилгээ үзүүлэх, сервер компьютерын ашиглалт, тохируулга, сүлжээний зохион байгуулалт, өргөтгөл шинэтгэлийг хариуцан гүйцэтгэх;
- 8.3.6 Техник хэрэгслийн хуваарилалт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, ашиглалтын байдлыг хариуцах, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт хийж, норм тогтоох, хангарт хийх ажлыг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах;
- 8.3.7 Улсын хэмжээнд зоонозын өвчний статистик мэдээг цуглуулах, бүртгэх, мэдээлэх, нэгтгэх, тайлagnaх, мэдээний сан үүсгэх, харьяа ЗӨСТ, нэгжүүдэд бүртгэл, мэдээллийн сургалт хийх, бүртгэл мэдээлэлд хяналт тавих, цахим бүртгэл нэвтрүүлэх, алсын зайн технологийг нэвтрүүлэн ажиллах;
- 8.3.8 ЗӨСТ-ийн мэргэжилтнүүдэд бүртгэл, мэдээллийн талаар сургалт хийх, хяналт тавих, цахим бүртгэл, алсын зайн технологийг нэвтрүүлэх;

8.4 Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын алба

- 8.4.1 Монгол улсын хэмжээнд зоонозын халдварт өвчний эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээний бодлого, чиглэлийг тодорхойлж, үндэсний хөтөлбөр, стратеги төлөвлөгөөг боловсруулан мэргэжлийн удирдлагаар хангах;
- 8.4.2 Зоонозын халдварт өвчний үйл явдалд болон шалгуур үзүүлэлтэд суурилсан тархалтыг тогтоох тандалт, судалгааг зохион байгуулж, байгалийн голомтын болон хүн амын дундах эрсдэлийн түвшинг тогтоох;
- 8.4.3 Зоонозын халварын хүний өвчлөл бүртгэгдсэн болон дэгдэлт гарсан тохиолдолд тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах, эрсдэлийг тооцож тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах;
- 8.4.4 Зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах,
- 8.4.5 Зоонозын халдварт өвчний хүн, мал эмнэлгийн салбар дундын зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд мэдээ, мэдээлэл солилцох, хамтарсан тандалт судалгаа хийх, эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулах;
- 8.4.6 Зоонозын гаралтай өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд олон нийт рүү хандсан сургалт сурталчилгаа явуулах, эрүүл мэндийн боловсрол олгох асуудлыг хариуцан гүйцэтгэх
- 8.4.7 Зоонозын халдварт өвчний чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхлэх, судалгааны дүн, зөвлөмж боловсруулах, мэдээний сан үүсгэх, анагаах ухааны ололт, амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах;
- 8.4.8 Улсын хэмжээнд зоонозын халдварт өвчний статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, мэдээлэх, дамжуулах, тайлagnaх, мэдээний сан үүсгэх үйл ажиллагааг хариуцах,

8.4.9 Зоонозын өвчний эмнэлзүй, тархвар судлал, гадаад орчин, халдвартын агуулагч, дамжуулагч амьтдын болон биотероризмын холбогдолтой сорьцод лабораторийн лавлах шинжилгээ хийж, үр дүнг баталгаажуулах;

8.5 Нэгдсэн лабораторийн алба

- 8.5.1 Тус алба нь лавлагаа лабораторийн болон ариутгал халдвартгүйтгэл, био үйлдвэрлэлийн 2 тасагтай, тасаг нь эрхлэгчтэй байна.
- 8.5.2 Зоонозын халдварт өвчний онош зүйн лавлагаа тусlamж, үйлчилгээ үзүүлэх;
- 8.5.3 Лабораторийн шинжилгээ, оношилгооны лавлах технологи, стандарт үйлдлийг боловсруулах, харьцуулан үнэлэх;
- 8.5.4 Лабораторийн шинжилгээний тэжээлт орчин, биобэлдмэл, үйлдвэрлэлийн чанар, стандарчлалыг хангах, технологийг шинэчлэх;
- 8.5.5 Лабораторийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;
- 8.5.6 Зоонозын өвчин үүсгэгч бичил биетний өсгөвөр, омог (нян, вирус, эгэл биетэн), эзэрэг сорьц (эсрэгтөрөгч, эсрэгбие)-ыг баталгаажуулах, өсгөвөр, эзэрэг сорьцын сан ажиллуулах, баяжуулах;
- 8.5.7 Аймаг, нийслэл дэх ЗӨСТ-ийн лабораторид лавлагаа үйлчилгээ үзүүлэх;
- 8.5.8 “Олон улсын эрүүл мэндийн дүрэм”, зоонозын халдварт өвчний талаарх Олон улсын болон Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөх, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан халдварт хамгааллын дэглэм болон биоаюулгүй ажиллагааны заавар журмыг баримтлах;
- 8.5.9 Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт болон голомтын үеийн ариутгал, халдвартгүйтгэл, мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэх;
- 8.5.10 Зоонозын халдварт өвчний оношилгоо, шинжилгээнд шаардлагатай микробиологийн тэжээлт орчин, будаг урвалж, уусмал, оношилгооны нян залгиурыг бэлтгэн нийлүүлэх, биотехнологийн үйлдвэрлэлийн технологийг сайжруулах;
- 8.5.11 Орон нутгийн ЗӨСТ-үүдийг чанарын шаардлага хангасан хэрэглэхэд хялбар, хямд үнэ, өргөн сонголт бүхий микробиологийн тэжээлт орчин, будаг урвалжаар хангах;
- 8.5.12 Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт болон голомтын үеийн ариутгал халдвартгүйтгэл, мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл, хог хаягдлын чиглэлээр сургалт зохион байгуулах, мэргэжилтэн бэлтгэх;

8.6 Санхүү хангамж үйлчилгээний алба

- 8.6.1 Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлон, байгууллагын хэмжээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авах;
- 8.6.2 Төвийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг олон улсын стандарт, “Төсвийн тухай” хууль, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, “Шилэн

- дансны тухай” хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад зааснаар гаргах;
- 8.6.3 Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллээр удирдлагыг хангах, санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулах, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
 - 8.6.4 Хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах, байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах;
 - 8.6.5 Төвийн барилга, цахилгаан, ус, дулаан хангамж, эд хогшил, эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашин, мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээтэй холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангана. Гадаад болон дотоод орчны тохижилтыг хийж, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах;

8.7 Чанарын алба

- 8.7.1 Зоонозын өвчний тусламж үйлчилгээнд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн чанар сайжруулах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах;
- 8.7.2 Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийх;
- 8.7.3 Хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийн талаар үнэлгээ хийх, хяналт шинжилгээний дунд үндэслэн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж гаргах, хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх аудитыг зохион байгуулах;
- 8.7.4 Дотоодын биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэлийн технологи бүтээгдэхүүнд чанарын хяналт, шинжилгээ хийж хэрэглээнд нийлүүлэх зөвшөөрөл олгох;
- 8.7.5 Эмнэлзүйн удирдамж, стандарт, хөтчийг ДЭМБ-ын зөвлөмж болон Олон улсын нотолгоонд сууриссан арга технологиор баяжуулан, шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;
- 8.7.6 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангах;